

ТАНИЛЦУУЛГА

Тогтоол хүчингүй болгох тухай
Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
тогтоолын төсөл боловсруулсан тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална” гэж заасан.

Энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Журам шинэчлэн батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 07 дугаар сарын 21-ний 09 дүгээр тогтоолыг батлан мөрдөж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт “Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална” гэж заасан.

Ийнхүү ажилгүйдлийн даатгалын сангаас даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газрын тогтоолоор батлах тул “Журам шинэчлэн батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 07 дугаар сарын 21-ний 09 дүгээр тогтоолыг хүчингүй болгох шаардлагатай.

Иймд “Тогтоол хүчингүй болгох тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төслийг боловсруулав.

Энэхүү тогтоолын төсөл батлагдсанаар ажил олгогч, даатгуулагч хууль тогтоомжийг нэг мөр ойлгож мөрдөх болно.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ